**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2024/151/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2024 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн захирал:Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com<br>Аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .............................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ...........
4. Аудитын тайлан ......................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ............................................................................................
   4.2 Материаллаг байдал .................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..............................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................
5. Аудитын илрүүлэлт .....................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 163

танай________________ны №________________т

ХАНГАЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ГЭРЭЛЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн ба улсын төсвөөс 184,102.7 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 23,042.1 мянган төгрөгийн нийт 207,144.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх онтой харьцуулахад 31,235.7 төгрөгөөр буюу 17.7-аар өссөн байна.

**Аудитын гол асуудал**

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 6 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулах болсон байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд есөн зорилтын хүрээнд дөчин таван арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд

006020376

гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.4 хувийн биелэлтэйгээр дүгнэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Боловсролын үнэлгээний төвөөс 2022 оны 11 дүгээр сарын 11 өдрийн 01/420 чиглэлийн дагуу "Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах удирдамж", "Төрийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах удирдамж"-ийн дагуу үнэлгээнд хамрагдаж байгууллага нь 3 түвшинд үнэлэгдэн багшийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг авсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 80,721,656.21 | 108,926,069.54 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 26,384,835.18 | 35,373,705.37 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 26,384,835.18 | 35,373,705.37 |
| 3122 | Гадаад валют | 26,384,835.18 | 35,373,705.37 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 26,384,835.18 | 35,373,705.37 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 54,336,821.03 | 73,552,364.17 |
| 351 | Түүхий эд материал | | 105,400.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | | 105,400.00 |
| 354 | Хангамжийн материал | 54,336,821.03 | 73,446,964.17 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 1,642,020.00 | 1,986,020.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 8,005,648.00 | 27,455,445.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 135,000.00 | 54,000.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 1,561,700.00 | 2,279,400.00 |
| 3546 | Хүнсний материал | 4,997,458.80 | 5,543,330.10 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 37,994,994.23 | 36,128,769.07 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 68,450,980.89 | 367,941,492.91 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 68,450,980.89 | 367,941,492.91 |
| 392 | Биет хөрөнгө | 61,801,980.89 | 361,629,992.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 174,540,883.74 | 476,540,883.74 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -127,001,247.84 | -132,244,428.72 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,161,621.00 | 21,900,621.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -13,179,967.53 | -16,387,251.75 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,328,345.00 | 5,405,640.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,001,514.00 | -3,956,988.87 |
| 39209 | Зам, гүрийн байгууламж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -1,050,000.00 | -1,200,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 549,000.00 | 20,089,817.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -368,250.48 | -10,341,410.49 |
| 39217 | Ном | 323,111.00 | 323,111.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 6,649,000.00 | 6,311,500.00 |
| 39301 | Программ хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -675,000.00 | -1,012,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,974,000.00 | 5,974,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 149,172,637.10 | 476,867,562.45 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 149,172,637.10 | 476,867,562.45 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 149,172,637.10 | 476,867,562.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 48,459,790.00 | 48,459,790.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 5,974,000.00 | 5,974,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 29,792,786.15 | 357,562,711.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 29,792,786.15 | 29,867,786.15 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 327,694,925.35 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 70,920,060.95 | 70,845,060.95 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 149,172,637.10 | 476,867,562.45 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 177,018,952.13 | 539,702,305.98 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,109,680.00 | 332,557,574.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,109,680.00 | 332,557,574.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,109,680.00 | 310,432,112.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 22,125,462.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 175,909,272.13 | 207,144,731.98 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 154,131,700.00 | 184,102,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 154,131,700.00 | 184,102,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 21,777,572.13 | 23,042,031.98 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 21,777,572.13 | 23,042,031.98 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 160,335,312.16 | 212,007,380.63 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 160,335,312.16 | 212,007,380.63 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 160,299,441.18 | 212,007,380.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 104,382,436.00 | 134,857,724.00 |
| 210101 | Үндсэн цалин | 80,233,297.00 | 100,972,910.18 |
| 210102 | Нэмэгдэл | 19,070,596.00 | 29,694,347.00 |
| 210104 | Урамшуулал | 5,078,543.00 | 4,190,466.82 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,754,257.97 | 17,008,072.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,872,146.00 | 11,593,934.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,043,781.86 | 1,355,904.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 835,025.42 | 1,078,123.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 175,746.63 | 268,298.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,827,558.06 | 2,711,809.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 13,668,722.00 | 19,242,031.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,221,302.00 | 2,347,631.98 |
| 210302 | Түлш, халаалт | 12,347,420.00 | 16,394,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,936,737.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | 317,410.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 200,827.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,159,400.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 259,100.00 | |
| 2105 | Норматив зардал | 11,161,963.00 | 12,268,017.20 |
| 210502 | Хоол, хүнс | 11,161,963.00 | 12,268,017.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 726,100.00 | 1,728,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 726,100.00 | 1,728,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 275,000.00 | 510,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 275,000.00 | 510,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,394,225.21 | 26,392,735.14 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,063,150.00 | 14,258,885.16 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,185,250.00 | 1,192,250.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,145,825.21 | 10,941,599.98 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,870.98 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 35,870.98 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,870.98 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 16,683,639.97 | 327,694,925.35 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 3,327,019.21 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,327,019.21 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -3,327,019.21 | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 13,356,620.76 | 327,694,925.35 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 175,909,272.13 | 207,144,731.98 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 175,909,272.13 | 207,144,731.98 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 154,131,700.00 | 184,102,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 154,131,700.00 | 184,102,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 21,777,572.13 | 23,042,031.98 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 21,777,572.13 | 23,042,031.98 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 149,524,436.95 | 198,155,861.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 149,524,436.95 | 198,155,861.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 149,488,565.97 | 198,155,861.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 104,378,186.00 | 134,857,724.00 |
| 210101 | Үндсэн цалин | 80,229,047.00 | 100,972,910.18 |
| 210102 | Нэмэгдэл | 19,070,596.00 | 29,694,347.00 |
| 210104 | Урамшуулал | 5,078,543.00 | 4,190,466.82 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,754,257.97 | 17,008,072.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,872,146.00 | 11,593,934.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,043,781.86 | 1,355,904.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 835,025.42 | 1,078,123.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 175,746.63 | 268,298.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,827,558.06 | 2,711,809.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 13,101,722.00 | 19,242,031.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,221,302.00 | 2,300,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,780,420.00 | 16,442,031.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,500,000.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | |
| 2105 | Норматив зардал | 10,993,350.00 | 12,756,033.50 |
| 210502 | Хоол, хүнс | 10,993,350.00 | 12,756,033.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 787,400.00 | 3,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 787,400.00 | 3,800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 275,000.00 | 510,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 275,000.00 | 510,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,698,650.00 | 9,981,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,498,650.00 | 8,450,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,200,000.00 | 1,531,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,870.98 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 35,870.98 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,870.98 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 26,384,835.18 | 8,988,870.19 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 26,384,835.18 | 8,988,870.19 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 26,384,835.18 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 35,373,705.37 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 20... оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл | 48,459,790.00 | 70,920,060.95 | 29,792,786.15 | 149,172,637.10 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 75,000.00 | 75,000.00 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -75,000.00 | | -75,000.00 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 327,694,925.35 | 327,694,925.35 |
| 19 | 20... оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл | 48,459,790.00 | 70,845,060.95 | 357,562,711.50 | 476,867,562.45 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 257,233,867.16 | 198,155,861.79 | 59,078,005.37 | 77.03 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 257,233,867.16 | 198,155,861.79 | 59,078,005.37 | 77.03 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 257,233,867.16 | 198,155,861.79 | 59,078,005.37 | 77.03 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 159,160,300.00 | 134,857,724.00 | 24,302,576.00 | 84.73 |
| 210101 | Үндсэн цалин | 111,305,200.00 | 100,972,910.18 | 10,332,289.82 | 90.72 |
| 210102 | Нэмэгдэл | 44,490,900.00 | 29,694,347.00 | 14,796,553.00 | 66.74 |
| 210104 | Урамшуулал | 3,364,200.00 | 4,190,466.82 | -826,266.82 | 124.56 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,720,400.00 | 17,008,072.31 | 2,712,327.69 | 86.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,409,700.00 | 11,593,934.94 | 1,815,765.06 | 86.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,577,900.00 | 1,355,904.92 | 221,995.08 | 85.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,262,200.00 | 1,078,123.91 | 184,076.09 | 85.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 315,600.00 | 268,298.70 | 47,301.30 | 85.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,155,000.00 | 2,711,809.84 | 443,190.16 | 85.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,626,867.16 | 19,242,031.98 | 26,384,835.18 | 42.17 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,300,000.00 | 2,300,000.00 | | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,826,867.16 | 16,442,031.98 | 26,384,835.18 | 38.39 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 500,000.00 | | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | | |
| 2105 | Норматив зардал | 18,434,300.00 | 12,756,033.50 | 5,678,266.50 | 69.20 |
| 210502 | Хоол, хүнс | 18,434,300.00 | 12,756,033.50 | 5,678,266.50 | 69.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,800,000.00 | 3,800,000.00 | | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,800,000.00 | 3,800,000.00 | | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 510,400.00 | 510,400.00 | | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 510,400.00 | | 510,400.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 510,400.00 | -510,400.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,981,600.00 | 9,981,600.00 | | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,450,400.00 | 8,450,400.00 | | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,531,200.00 | 1,531,200.00 | | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | | | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 257,233,867.16 | 207,144,731.98 | 50,089,135.18 | 80.53 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 207,807,000.00 | 184,102,700.00 | 23,704,300.00 | 88.59 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | 184,102,700.00 | -184,102,700.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 207,807,000.00 | | 207,807,000.00 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 23,042,031.98 | 23,042,031.98 | | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 23,042,031.98 | 23,042,031.98 | | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 26,384,835.18 | | 26,384,835.18 | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 26,384,835.18 | | 26,384,835.18 | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 26,384,835.18 | -26,384,835.18 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 35,373,705.37 | -35,373,705.37 | |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хангал сумын цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх зорилго бүхий төрийн үйлчилгээний байгууллага бөгөөд сургуулийн өмнөх боловсролын зорилгод заасан боловсролын зорилгыг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг төрийн байгууллага юм.

Хангал сумын цэцэрлэг нь 1967 онд бага сургуулийн дэргэд 15 хүүхэдтэй, Тогооч, галч, угаагч, багш гэсэн 4 орон тоотойгоор гэр цэцэрлэгийн байдлаар байгуулагдаж байсан. 1995 оноос хүүхдийн тоо багасаад сургуультай нэгдэж нэг бүлэгтэйгээр ажиллаж байв. 2000 оноос худалдаа бэлтгэл ангийн дэлгүүрийн байранд "Цагаан тавилан" ХХК-ны хөрөнгө оруулалтаар 6.6 сая төгрөгөөр өөрийн байртай, халамжийн 25 хүүхэд, төсвийн 20 хүүхэдтэйгээр ажиллаж эхэлсэн юм.

Хангал сумын цэцэрлэг 2000 оноос хойш хийсэн ажил нь: "Цагаан тавилан" ХХК нь нэг бүлгийг бүрэн тохижуулж өгсөн. Өөрсдийн хүч бололцоог ашиглан хүүхдийн

тоглоомын талбайтай болж, "Дэлхийн зөн Монгол" Олон улсын байгууллагаас 18 хүүхдийн бүтэн жилийн хоолны мөнгийг хариуцаж байв.

2002 оноос төсөлд хамрагдаж хоёр гэр цэцэрлэгтэй болсноор өнөөг хүртэл тасралтгүй малчдын хүүхдэд хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэн ажиллаж байна.

2007-2010 онд хүүхдийн тоо багасаж байгаад 2012 оноос тус цэцэрлэгт 2-5 хүртэлх насны 38 хүүхдийг ахлах, бага бүлэгт хамруулан ажилласан.

2023 онд Холимог насаар бага, ахлах гэсэн 2 бүлэгтэй үйл ажиллагаа явуулж байна.

2023 онд тус цэцэрлэг нь эрхлэгч 1, бүлгийн багш 2, туслах багш 2, нярав 1, тогооч 1, үйлчлэгч 1, слесарь 1, нягтлан бодогч 0.5 нийт 8.5 орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулж байна.

2023-2024 оны хичээлийн жилд “Эрдэнэт” ТӨҮГ-ын 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн стандарт шинэ цэцэрлэгийн байрыг 2024 оны 1 дүгээр улиралд хүлээн авахаар ажиллаж байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд 2023 онд Боловсролын тухай хуульд өөрчлөлт орсноор Боловсролын удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын үндэсний зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, боловсролын байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллагын удирдлагаас бүрдэхээр хуульчлагдсан байна. Иймд тус цэцэрлэг нь 2023 оны 07 дугаар сарын 01-ээс Булган аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны Газрын даргатай гүйцэтгэлийн гэрээг байгуулж, тайлагнаж, үр дүнг тооцуулан ажиллаж байна.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтыг дэвшүүлэн 32 арга хэмжээг төлөвлөж ажилласан бай гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 96.0%-тай дүгнэгдсэн байна.

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэг нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн дагуу 2-5 насны хүүхдийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадвартай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах, хөгжих чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролыг олгож байна.

Тус байгууллага нь тайлант санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогод дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Улсын Засгийн газрын 2023 оны 241, 242 дугаар тогтоол

- Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай нэмэлт өөрчлөлт орсон.
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 272 дугаар тогтоолоор "Журам батлах тухай"
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 5 дахь заалт"-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан,
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 86 дугаар "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ыг баталсан өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн эгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу дотоод хяналтын нэгж байгуулж, тайлант онд хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч үр дүн хангалттай биш байна. Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг дарга, нягтлан бодогч нар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайн байгууллагад дотоод аудитыг хэрэгжүүлэх нэгж, ажилтан байхгүй байгаа ба дээд шатны байгууллагаас дотоод аудитыг тайлант онд хэрэгжүүлээгүй байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэг нь Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ыг мөрдөж ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг Си Ти Эйс санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн программ нь Сангийн яаманд хүлээн зөвшөөрөгдсөн, төсвийн байгууллагын онцлогт тохирсон данс, бүртгэлийн системтэй бөгөөд УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд нийцсэн иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглаж байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 327,695.0 мянган төгрөгөөр буюу 96.7 хувиар өссөн байна. Энэ нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оныхоос 35,373.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй, энэ нь 302,000.0 мянган төгрөгөөр барилга байгууламж нэмэгдсэнтэй холбоотой юм. 2024 онд шинэ цэцэрлэгийн барилга хүлээн авах болсонтой холбоотой бөгөөд 302,000.0 мянган төгрөгийн барилга нь тус цэцэрлэгийн барилгын эхний хэсгийг хүлээн авсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 26,384.8 | 35,373.7 | 8,988.9 |
| Бараа материал | 54,336.8 | 73,552.4 | 19,215.6 |
| Үндсэн хөрөнгө | 68,450.9 | 367,941.5 | 299,490.6 |
| **Нийт хөрөнгө** | **149,172.6** | **476,867.6** | **327,695.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 149,172.6 | 476,867.6 | 327,695.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **149,172.6** | **476,867.6** | **327,695.0** |

Хүснэгт дэх 2023 оны үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд салбарын бодлогын шинэчлэлтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгө 35,373.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалыг худалдан авсан буюу олж бэлтгэсэн үнээр нь бүртгэсэн. Бараа материалын дансанд 46,385.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна. Үүнээс тайлант онд 21,897.6 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар авч холбогдох дансанд бүртгэсэн байна. Үүнээс гадна 24,430.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь хүлээн зөвшөөрч, шулуун шугамын аргаар элэгдлийг тооцсон байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд 327,125.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнээс 3,972.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Булган аймгийн Засаг даргын тамгын газраас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. 21,153.8 мянган төгрөгийн хөрөнгийг мөн үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн 302,000.0 мянган төгрөгийн барилга байгууламжийг хүлээн авсантай бөгөөд дээрх хөрөнгүүдийг хүлээн авч холбогдох данс бүртгэлд тусгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэг нь 2023 оны нийт үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд шаардлагатай санхүүжүүлэлтийг 210,481.5 мянган төгрөг байхаар тооцон холбогдох дээд шатны төсвийн захирагчид хуулийн хугацаанд саналыг хүргүүлсэн байна.

Холбогдох дээд шатны байгууллагаас тус цэцэрлэгийн 2023 оны нийт үйл ажиллагааны зардлыг 184,102.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд дээд шатны байгууллагаас 2023 оны төсвийн төсөлд өгсөн саналыг 26,378.8 мянган төгрөгөөр буруулан баталсан байна. Тайлант онд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор холбогдох дээд шатны байгууллагаас тус цэцэрлэгийн төсөвт 219,476.4 мянган төгрөгийн тодотгол хийсэн байна.

2023 онд санхүүжих тогтмол зардлын санхүүжилтийг 23,042.1 мянган төгрөгөөр тооцон Булган аймгийн төрийн санд хүргүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс 2023 оны тогтмол зардлын санхүүжилтийг 23,042.1 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант хугацаанд тодотгол хийгдээгүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 184,102.7 мянган төгрөг, орон нутгаас тогтмол зардал, урсгал засварын зардлыг санхүүжүүлэхээр 23,042.1 мянган төгрөгийг нийт 207,144.7 мянган төгрөгөөр эх үүсвэрийг баталсан байна.

Төсвийн зарлагын төлөвлөгөөг 257,233.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 198,155.8 мянган төгрөг зарцуулж төсвийн гүйцэтгэл 77.03%-ийн биелэлттэй байна. Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 35,373.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 257,233,867.16 | 198,155,861.79 | 59,078,005.37 | 77.03 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 257,233,867.16 | 198,155,861.79 | 59,078,005.37 | 77.03 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 257,233,867.16 | 198,155,861.79 | 59,078,005.37 | 77.03 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 159,160,300.00 | 134,857,724.00 | 24,302,576.00 | 84.73 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,720,400.00 | 17,008,072.31 | 2,712,327.69 | 86.25 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,626,867.16 | 19,242,031.98 | 26,384,835.18 | 42.17 |
| 2105 | Норматив зардал | 18,434,300.00 | 12,756,033.50 | 5,678,266.50 | 69.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,800,000.00 | 3,800,000.00 | | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 510,400.00 | 510,400.00 | | 100 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,981,600.00 | 9,981,600.00 | | 100 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 257,233,867.16 | 207,144,731.98 | 50,089,135.18 | 80.53 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 207,807,000.00 | 184,102,700.00 | 23,704,300.00 | 88.59 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | 184,102,700.00 | -184,102,700.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 207,807,000.00 | | 207,807,000.00 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 23,042,031.98 | 23,042,031.98 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 23,042,031.98 | 23,042,031.98 | | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 26,384,835.18 | | 26,384,835.18 | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 26,384,835.18 | | 26,384,835.18 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 26,384,835.18 | -26,384,835.18 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 35,373,705.37 | -35,373,705.37 | |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд салбарын хэмжээнд нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан бөгөөд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах төлөвлөгөө хийж байгууллагын удирдлагаар батлуулаагүй байна. Тайлант онд хүүхдийн хоолны материалыг 12,756.1 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 8,450.4 мянган төгрөгийн, хичээл практикийн 1,531.2 мянган төгрөгийн материалыг, урсгал засварын материалыг 3,800.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авалт хийсэн бөгөөд худалдан авалтыг хийхдээ харилцагч байгууллагуудтай худалдан авалт болон хамтран ажиллах гэрээг байгуулсан байна.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл” гэж заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт ирүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор Б.Пүрэвсүрэн, аудиторын туслах Б.Норовсүрэн нар гүйцэтгэж анхан шатны чанарын хяналтыг салбарын захирал, аудитор Д.Мягмарсүрэн, хоёр дахь шатны

чанарын хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дараагийн шатны хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвөөс бүрддэг тул 2022 оны төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг материаллаг суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт 160,335.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,603.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,122.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 35 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт болон төсвийн хөрөнгийн зарцуулалт, бусад анхаарал хандуулах асуудлууд зэргийг тусгайлан авч, хяналтыг хэрэгжүүлэхэд 23,783.9 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байв.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2- 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

<u>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд авсан судалгааны үр дүн: А</u>втомашин, орлогч дарга, бэлэг дурсгал, цахим худалдан авалттай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгахад шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Тус байгууллага нь тайланд шилэн дансны сайтад 159 мэдээлэл байршуулахаас 158 мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлсэн, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлээгүй, 4,460.1 мянган төгрөгийн хандиваар авсан хөрөнгийн шийдвэрийг шилэн дансны системд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг цаашид дахин давтахгүй байхаар анхааруулж, зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Булган аймгийн Хангал сумын цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого, төсвийн орлого, зардлын зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн.

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдэлд биет тооллого хийсэн ба ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй бөгөөд асуудлын бүртгэлээр 5 зөвлөмж өгсөн бөгөөд биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянан үзэхэд биелэлт хангасан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 473,024.0 мянган төгрөгийн алдаа1 илэрснээс аудитын явцад 41,893.4 мянган төгрөгийн алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн2 алдааг дахин давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгөв

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Залруулсан алдаа | 1 | 41,893.4 | 1 | 147,149.4 | |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 3 | 431,130.6 | 3 | 431,130.6 | 100% |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **4** | **473,024.0** | **4** | **473,024.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, 2024 онд тус цэцэрлэгийн хөтөлбөр арга хэмжээний зардал нь зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэх, нүүдлийн гэр цэцэрлэгийн үйл ажиллагаанд  хяналт хийх нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,141.4 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 1 албан шаардлага, 8,141.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Хүнсний материал худалдан авах ажиллагааны тендерийн материал шаардлага хангахгүй байна. Үнийн санал аваагүй, гэрээ хэлцэлгүй худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.1.-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”. 33.2.-т “Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ”, 33.2.1.-д “Үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;”, 33.2.2.-д “Техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох”, гэсэн заалтыг зөрчиж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:  Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д ”бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн.” гэж заасны дагуу төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

**1. <u>Зардлын данстай холбоотой асуудал</u>**

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Цэцэрлэгийн хоолны цэс, технологийн карт, өдөрлөг бүгд зөрүүтэй хоолны материал бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, тухайн өдрийн өдөрлөгөөр гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 5.1.3.-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах.

2. **Хөрөнгийн данстай холбоотой асуудал.**

Илрүүлэлт: Эд хариуцагчийн карт шинэчлэгдээгүй, үндсэн хөрөнгө бараа материалын хагас жилийн тооллого хийгдээгүй, биет тооллого хийхэд бараа материалын дансанд 50.0 мянган төгрөгийн бензин талон илүү, хөрөнгийн дансанд 288.7 мянган төгрөгийн хөргөгч, зурагт биетээр байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.2-д “Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/хийнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэсэн заалт зөрчиж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

3. **Хөрөнгийн данстай холбоотой асуудал.**

Илрүүлэлт: Ашиглалтын хугацаа дууссан болон анхны өртгөө нөхсөн 11 нэр төрлийн 11 ширхэг 7 802.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.

Энэ нь Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчигдөж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах, Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагаатай холбоотой | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Анхан шатны баримтын иж бүрдэлтэй холбоотой | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой | 1 | 7,802.6 | | | | | 1 | 7,802.6 | | | | |
| Эд хөрөнгийн тооллоготой холбоотой | 1 | 338.8 | | | | | 1 | 338.8 | | | | |
| Дүн | 4 | 8,141.4 | | | 1 | - | 2 | 8,141.4 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | 4,460.1 | | | | | 1 | 4,460.1 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 4,460.1 | | | | | 1 | 4,460.1 |